



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 30 өдөр




Дугаар А/58

Улаанбаатар хот

Дүрэм, бүтэц батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4 дүгээр заалт, "Номын сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 196 дугаар тогтоолын 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Үндэсний номын сангийн дүрэм"-ийг нэгдүгээр, "Монгол Улсын Үндэсний номын сангийн бүтэц"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Номын сангийн дүрмийг мөрдөж, батлагдсан бүтэц, орон тоонд багтаан ажлын байрыг оновчтой тогтоон ажиллахыг Монгол Улсын Үндэсний номын сангийн захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Ичинхорлоо/-д даалгасугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Дүрэм, бүтэц батлах тухай" Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 31 дүгээр тушаалын 1 дүгээр заалтын "Монгол Улсын Үндэсний номын сангийн дүрэм"-ийг нэгдүгээр, "Монгол Улсын Үндэсний номын сангийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц"-ийн хоёрдугаар гэсэн хэсэг, нэг, хоёрдугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



3 0173

Боловсрол, соёл, үнэмлэхүй ухаан, спортын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 16 өдрийн 158 дугаар тушаалын нэгдүгээр хэсгээр

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН ДҮРЭГ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үндэсний номын сан нь хэвлэлийн бүтээгдэхүүний сан хөмрөг бүрдүүлэх хадгалах, хамгаалах, номын сан, ном зүй, ном судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ-судалгааны ажил эрхлэх, улсын нэгдсэн каталогийн үндэсний ном зүйг эрхлэн гаргах, бүртгэл мэдээллийн санг бий болгох, уншигчдад үйлчлэх, бусад номын санг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах байгууллага мөн.

1.2. Номын сан нь үйл ажиллагаандаа Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг мөрдлөг болгоно.

1.3. Номын сан нь "Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага" MNS 5742 : 2007, "Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага" MNS ISO 11 799:2007 стандартыг тус тус хэрэгжүүлнэ.

Хоёр. Үндэсний номын сангийн үйл ажиллагааны зарчим, үндсэн чиг үүрэг

2.1. Үндэсний номын сан нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг удирдлага болгоно:

- 2.1.1. мэргэжлийн хэм хэмжээг сахих,
- 2.1.2. тасралтгүй хөгжих,
- 2.1.3. үйлчилгээний эрх тэгш, хүртээмжтэй байдлыг хангах,
- 2.1.4. ил тод, нээлттэй байх.

2.2. Үндэсний номын сан нь хууль тогтоомжид заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1. Хэвлэлийн бүтээгдэхүүний үндэсний сан хөмрөг бүрдүүлэх зорилгоор баримтат өвийн зайлшгүй хадгалах сан хөмрөгийг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах.

2.2.2. Эртний болон орчин үеийн ном хэвлэлийн бүтээгдэхүүн, мэдээллийн бусад эх сурвалжийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, сэргээн засварлах, хадгалах, хамгаалах, олон нийтэд сурталчлан таниулах.

2.2.3. Номын сан, ном зүй, ном судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг бие даан хийхийн зэрэгцээ бусдаар захиалан гүйцэтгүүлэх.

2.2.4. Үндэсний ном зүй болон улсын нэгдсэн каталогийн мэдээллийн нэгдсэн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх.

2.2.5. Түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах ном, судрыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу бүртгүүлж, хамгаалах.

2.2.6. Бусад номын санг харьяалал харгалзахгүй Монгол Улсын хэмжээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

2.2.7. Номын сангийн үйлчилгээ эрхлэх, уншлагыг дэмжих олон талт ажил зохион байгуулах.



172
Боловсрол, соёл, үнэмлэхүй ухаан, спортын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 16 өдрийн 158 дугаар тушаалын нэгдүгээр хэсгээр

2.2.8.Салбарын болон байгууллагын, хүний нөөцийг чадвахижуулах чиглэлээр сургалт зохион байгуулах, гарын авлага, материал боловсруулах, ном, товхимол гаргах.

2.2.9. Байгууллагын чиг үүрэгт хамаарах асуудлаар ижил, төстэй гадаад, дотоодын байгууллагатай хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулах, гадаад, дотоодын номын сан хоорондын ном солилцоог өргөжүүлэх.

2.2.10. Номын сан, ном зүйн мэдээллийг автоматжуулах, үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, цахим мэдээллийн санг бий болгох.

2.2.11.Номын сангийн сан хөмрөгийн эргэлтэд байнга судалгаа хийж, бүрдүүлэлтийн чанарыг сайжруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах.

2.2.12. Номын сангийн бичиг баримтын бүрдүүлэлт, архивын нэгжийг Архивын тухай хууль, "Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг" MNS 5140-1:2011, MNS 5140-2:2011, стандарт, "Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар", "Байгууллагын архивын ажлын үндсэн заавар"-ыг тус тус мөрдөн бүрдүүлж, архивт шилжүүлэх.

2.2.13. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа хэвлэлийн бүтээгдэхүүнийг анхан шатны бүртгэл, хөрөнгийн бүртгэлд тусгах, номын тооллого хийх ажлыг зохион байгуулах.

Гурав. Үндэсний номын сангийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц

3.1. Үндэсний номын сангийн дүрэм, бүтцийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.2. Үндэсний номын сангийн дэргэд Эрдмийн болон Мэргэжлийн зөвлөл, Захиргааны зөвлөл ажиллана. Номын сангийн Эрдмийн болон Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Захиргааны зөвлөлийн журмыг номын сангийн захирал тус тус батална.

3.3. Үндэсний номын сангийн захирлыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль тогтоомжид нийцүүлэн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилж, чөлөөлнө.

3.4. Захирал соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд ажлаа тайлагнах бөгөөд дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3.4.1. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулах;

3.4.2. Батлагдсан төсвөө захиран зарцуулах, төсвийг зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулах.


3.4.3. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан орон тоог батлах, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох.

3.4.3. Номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээнд дагаж мөрдөх дүрэм, журмыг батлах мөрдүүлэх.

3.4.4. Байгууллагын стратеги хөгжлийн урт, дунд, богино хугацааны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, хэрэгжүүлэх.

3.4.5 Номын сангийн ажиллагсдыг ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуурыг хангасан иргэнийг ажилд томилж, чөлөөлөх.

3.4.6. Байгууллагын хэмжээнд мөрдөгдөх дотоод журам, дүрмийг хууль тогтоомжид нийцүүлэн батлах.



438
Хууль, соёл, спорт, урлаг, бие даах
спортын яам
ХҮҮЛИЙН ХЭЛТЭС
ХҮҮЛБАР ҮНӨН
Хууль бар олгосон ажлын гарын үсэг
18 оны 11 сарын 16

3.4.7. Номын сангийн барилга байгууламж, сан хөмрөгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, үймээн самуун, гэмт халдлагын үед устаж үрэгдэж болзошгүй бусад нөлөөллөөс хамгаалах, аюулгүй байдлыг хангах.

3.4.8. Уншигчдад үйлчлэх болон номын санчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах.

3.4.9. Байгууллагын чиг үүрэгт хамаарах асуудлаар байгууллага, иргэнтэй хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулах.

3.4.10. Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан "Ажлын цагийг нэгтгэн бодох журам"-ыг баримтлан ажиллагсдын ажил, амралтын цагийг зохицуулах.

3.4.11. Хууль тогтоомж, байгууллагын дүрэм, дотоод журмыг зөрчсөн ажиллагсдад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх.

Дөрөв. Үйлчилгээний хүрээ, ажлын цагийн үргэлжлэл

4.1. Үндэсний номын сан нь "Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийн тухай хууль"-д заасан нийтээр тэмдэглэх баярын өдрүүдээс бусад өдрүүдэд ажиллана.

4.2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас бусад иргэн, хуулийн этгээдэд үйлчилнэ.

4.3. Номын сангийн ажлын цагийн үргэлжлэлийг өвөл, зуны цагийн хуваарийн дагуу Захирал батална.

Тав. Эд хөрөнгө, санхүүжилт

5.1. Үндэсний номын сангийн хөрөнгө дараах зүйлээс бүрдэнэ.

5.1.1. Байгууллагын үндсэн хөрөнгөд тусгагдсан газар, барилга, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгө, буцалтгүй тусламжийн хүрээнд ирүүлсэн тоног төхөөрөмж,

5.1.2. Байгууллага, иргэдээс хандивласан эд хөрөнгө, тоног төхөөрөмж, бусад зүйл.

5.2. Номын сангийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

5.2.1. Улсын төсөв,

5.2.2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого,

5.2.3. Хөрөнгө оруулалт, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, буцалтгүй тусламж,

5.2.4. Гадаад улс, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл,

5.2.5. Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад ашиг орлого.

5.3. Байгууллага, иргэдээс болон гадаад, дотоодын хандивлагчдаас ирүүлсэн хандивын хөрөнгийг жил бүр төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнаж, үндсэн хөрөнгийн бүртгэл тайлан балансад бүрэн тусгаж, байгууллага дээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа, үр дүнг ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээнд тусган тайлагнаж ажиллана.


2018 11 19

сэр. өдөр Бүртгэлийн № ... 7486
Нийслэлийн Сүхбаатар дүүргийн
иргэдийн нотариатч П.Хишигжаргал би. 422
Энэ хуулбарын үнэн зөвийг гэрчилж, тусгай
Үйлчилгээний хөдсөнд 170 тусгай раав
Нотариатч
18 оны 11 сарын 16

Байнгын байрны дүгээр сарын 11-ийн өдрийн хуралын хуралт



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН БҮТЭЦ



2018.11.19 өдөр Бүртгэлийн № 7432
 Нийслэлийн баятар дүүргийн
 Говьсүмбэр хотын 17 Хийсгэжээгч 6-
 анд хуульчдын үнэн зөвний гэрчилгээ
 Үйлчилгээний хэлтэсд 500 Тогтоол /Гурав
 Нотариус /
[Signature]

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН БҮТЭЦ
 ОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААД,
 СПОРТЫН ЯАМ
 ХУУЛИЙН ХЭЛТЭС
 ХУУЛЬЧАР ҮНЭН
 /Лбар олгосон ажилтны гарын үсэг/
[Signature]
 2018 оны 11 сарын 18-ний өдөр